



“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗАР”-ЫН ДАРГА Л.БЯМБАСҮРЭН
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 24 № 3/558
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу “Иргэний нисэхийн ерөнхий газар”-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Иргэний нисэхийн ерөнхий газар”-ын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг УСНББОУС-ын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Бид аудитыг Аудитын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.


Санал дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнд дийлэнх буюу 70.2 хувийг эзлэж буй Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлаг, Нисэх хөдөлгөөний алба, Үйлдвэрлэлийн албадын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 12,960.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 10,348.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,604.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол "Иргэний нисэхийн ерөнхий газар"-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн Сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2016ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Санхүүгийн аудитын
газрын дарга, Тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Naranchimegts@audit.gov.mn
Утас: 261663

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Аудитын менежер Я.Самбууням
Sambuunyamyа@audit.gov.mn
Утас: 260512

Ахлах аудитор Н.Батсайхан
Batsaikhann@audit.gov.mn
Утас: 260512

Аудитор Б.Сэржмядаг
Serjmyadagb@audit.gov.mn
Утас: 260512

Аудитор Н.Нямдаваа
Nyamdavaan@audit.gov.mn
Утас: 260512

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс

2017оны 03 сарын 25

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт
17. Менежментийн захидал

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.(САГ-2017/22/СТА-ТТЗ)

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөхөд энэхүү аудитын зорилт оршино.

Тус газрын удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 03 дугаар сарын 15-25-ны хооронд хийхээр төлөвлөн Ахлах аудитор Н.Батсайхан, аудитор Н.Нямдваа, аудитор Б.Сэржмядаг наргүйцэтгэв./ТАБ-СТА-А-9/

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдөр 2017 оны 3 дугаар сарын 03-ны 02/811 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн нь Төсвийн тухай хуульд заасан цаглабрын хугацааг 10 хоног хоцроосон байна.

Аудитын багаудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэж, аудитын хийсэн санхүүгийн тайланг 2017 оны 3 дугаар сарын 24-нд Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлага нь Монгол улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Засгын газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульболон бусад хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, заавартзарим өөрчлөлт орсонбайна.

3. Байгууллагын зорилго, үйлажиллагаа:

Иргэний нисэхийн ерөнхий газрын эрхэм зорилго нь Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх, нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо, навигацийн техник тоног төхөөрөмж, мэдээлэл хангалт, нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ үзүүлж, үндэсний эдийн засагт хувь нэмэр оруулахад оршино.

Иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх дараах чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;
- Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- Агаарын хөлгийн нислэгт холбоо навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх;
- Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх;
- Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх;
- Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх;
- Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох;
- Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж, боловсруулах, хэрэгжилтийг хангах зэрэг үндсэн үүргүүдийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.3-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно”, 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 15.4.2-т “энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрындарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судлахад Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрынАгентлагийн 2016 оны төсвийн үйл ажиллагааны зардлыг төрийн сангаас бүрдүүлдэг болҮйлдвэрлэлийн албанаасНисэх хөдөлгөөн үйлчилгээний алба, бусад салбар нэгжийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлдэг байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын Үйлдвэрлэлийн алба, Нисэх хөдөлгөөн үйлчилгээний алба, Агентлагийн болон бусад салбар нэгжийн ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Иргэний нисэхийн ерөнхий газрын2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 21 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байгаа ба энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС, нягтлан бодох бүртгэлийн програмтай нийцсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд дундбуюу мэдээллийн технологийн мэргэжилтэний оролцоо шаардагдах магадлалтай гэсэн үнэлгээ авсан боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитыг шууд гүйцэтгэлээ./ТАБ-СТА-В-2/

Иргэний нисэхийн ерөнхий газрынсанхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн“Макс” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх, нэгтгэл хийх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2017 оны 1 дүгээр сараас эхлэн санхүүгийн Макс програмыг өөрчилж Интерактив ХХК-ний ERP програмыг нэвтрүүлэн системийн байгууллагууд ашиглаж эхэлсэн байна.

Материаллаг байдал:

Материаллаг байдлын суурийг нийт орлогоос тооцохоор шийдлээ. Учир нь тус нэгтгэл тайланд Үйлдвэрлэлийн албанд төвлөрсөн орлого дийлэнх хувийг эзэлдэг бөгөөд уг төвлөрсөн орлогоос бусад харьяа байгууллагуудыг санхүүжүүлдэг байна. Гүйцэтгэлийн үе шатанд нийт орлогыг суурь болгон материаллаг байдлыг 1 хувиар буюу 2,226.8 сая төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

5. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзэн дахин хянасан.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Тус газрын дотоод аудит нь 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод аудит хийх хуваарийг ИНЕГ-ын даргаар батлуулан, батлагдсан хуваарийн дагуу тус газрын дотоод зохион байгуулалтын нэгж болон түүний харьяа үйлдвэрлэл үйлчилгээний 4 байгууллагад төлөвлөгөөт, 17 газарт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн ба нийт 9,037.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж 48 зөвлөмж өгчээ.

6. Орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 онд агентлагийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар хянуулж, батлагдсан төсвийн хүрээнд Төрийн сангаас харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн ба төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Мөн тус газрын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардлын хувьд Сангийн Сайд, Зам, тээврийн хөгжлийн Сайдын хамтарсан тушаалаар баталдаг байна. Үүнд:

- Системийн хэмжээнд өнгөрөлтийн орлогоос(навигаци) 161,619.6 сая төгрөг,
- Буулт хөөрөлтийн орлогоос 8,978.8 сая төгрөг,
- Зорчигч үйлчилгээний орлогоос 8,773.8 сая төгрөг,
- Шатахуун борлуусны орлогоос 2,000.0 сая төгрөг,
- Шүүхийн шийдвэрийн дагуу буцаан төвлөрүүлэх орлого 1,436.5 сая төгрөг,
- Бусад орлогоос 6,250.8 сая төгрөг нийт 189,059.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулахаар нийт орлогын төлөвлөгөө батлагдсан байна.

Үүнээс Улсын төсөвт 103,087.1 сая төгрөгийн өнгөрөлтийн орлого(навигаци) төвлөрүүлэхээс 115,844.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Мөн 2016 онд Зам, тээврийн хөгжлийн Сайдын 170 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр 13,500 сая төгрөг, 156 дугаар тушаалаар 2015 оны цэвэр ашгаас 4,900.0 сая төгрөг, 32 дугаар тушаалаар Төсвийн тухай хуульд батлагдсанаар

Хөгжлийн банкны эх үүсвэрээр эргэн төлөх нөхцөлтэй 2,181.0 сая төгрөг, системийн нийт урсгал зардлын төсөвт 2,500.0 сая төгрөг нийт 23,081.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 119 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ. Гүйцэтгэлээр нийт 16,136.6 сая төгрөгийн 106 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- 2015 оны цэвэр ашгаас 3,762.4 сая төгрөг,
- Улсын төсвийн санхүүжилтээс 5,343.9 сая төгрөг,
- Хөгжлийн банкны эх үүсвэрээс 646.1 сая төгрөг,
- Тайлант оны батлагдсан төсвөөс 1,701.6 сая төгрөг,
- Бусад 4,682.6 сая төгрөг нийт 16,136.6 сая төгрөгийн 106 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх төлөвлөгөөгөөр төлөвлөлтийн шатанд 8 дансанд 40 эрсдэл байж болзошгүй гэж тогтоосны дагуу нарийвчилсан сорилын аргаар тулган баталгаажуулах, ажиглах, харьцуулах зэрэг сорилыг гүйцэтгэлээ.

Санхүүгийн аудитын төлөвлөлтийн үе шатыг 11, гүйцэтгэлийн үе шатыг 8, тайлагналын үе шатыг 5 ажилбараар тус тус гүйцэтгэлээ.

Мөн үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, нотлох баримтуудыг бүрдүүлсэн.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Үр дагаварыг тодорхойлвол: Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авлага өмнөх оноос 7,334.3 сая төгрөгөөр буурсан, нийт өр төлбөр 3,063.7 сая төгрөгөөр үүнээс татварын өр 2,722.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт авлагад дийлэнх буюу 87.2 хувийг гадаад, дотоодын авиакомпаниудаас авах 38,316.3 сая төгрөгийн авлага эзлэж байгаа бөгөөд үүнд гадаадын дампуурсан авиакомпаниудаас авах 1998-2005 онд үүссэн 1,993.3 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, жилийн эцсийн аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгийн дүнд харьцуулсан, зэрэгцүүлсэн дүн шинжилгээ хийж, зарим томоохон дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэн шалгалаа. (ТАБ-СТА-В-3)

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлаг, Үйлдвэрлэлийн алба, Нисэхийн хөдөлгөөний алба, Чингис хаан Олон Улсын нисэх буудал, Газрын үйлчилгээний алба,

Сэргээн засах сувилал цогцолбор, 15 аймгийн нисэх онгоцны нийт 21 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Нэгтгэлд хамрагдсан нийт 21 санхүүгийн тайлангаас МУ-ын Ерөнхий аудиторын тушаалаар 6 нэгжийн санхүүгийн тайланд ХАК аудит хийж, 3 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан, 4 аймагийн нисэх буудлын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 12 санхүүгийн тайланд АОНА газар аудит хийж дүгнэлт өгснөөс Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлаг, Үйлдвэрлэлийн алба, Нисэхийн хөдөлгөөний албаны 3 санхүүгийн тайланг нэгтгэн 1 хязгаарлалттай дүгнэлт өгсөн, бусад 9 санхүүгийн тайлан зөрчилгүй санал дүгнэлттэй нэгтгэлд хамрагдсан байна.

Зарим төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын талаар:

Монгол Улсын ерөнхий аудиторын тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн тайланд “Энич аудит” ХХК аудит хийсэн бөгөөд Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлаг, Нисэх хөдөлгөөний алба, Үйлдвэрлэлийн албадын 2016 оны санхүүгийн тайланд ямар ч эрх зүйн актгүйгээр нэгтгэж дунд нь нэг дүгнэлт өгсөн байна.

“Энич аудит” ХХК аудитыг 2016 оны 3 дугаар сарын 23-нд эцэслэж аудитын дүгнэлт гаргуулсан бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан цаглабрын хугацааг 8 хоногоор хоцроон, Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээний хугацааг зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ-аас аудит хийх, аудитын горим сорил хэрэгжүүлэхэд цаг хугацаагүй болгож хүндрэл бэрхшээл үүсгэж байв.

10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ-аас хийсэн аудитаар дараах асуудлууд байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн нэгтгэсэн тайланд 315,703.1 сая төгрөгийн давхардсан гүйлгээг устгаагүй тайлагнасан нь СС-ын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад мөнгөн гүйлгээний тайланг залруулав.

2. Нийт 43,946.2 сая төгрөгийн авлагаас 2,071.3 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, үүнээс 2,070.7 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн байна. Үүнд 1998-2005 онд үүссэн гадаадын авиа компаниас авах 1,993.3 сая төгрөгийн авлага байгаа нь ОХУ-ын дампуурсан 12 компанитай холбоотой байна.

Шийдвэрлэсэн: Энич аудит ХХК-иас гаргасан аудитын тайланд дурьдагдаж, албан шаардлага хүргүүлсэн тул асуудлын бүртгэлд тусгав.

3. Нийт 9,560.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлээс 5.9 сая төгрөгийн өрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь 2011 онд үүссэн "Идэр авиашн" ХХК-д өгөх навигацын барьцааны өглөг бөгөөд уг өглөгийг авах тухай асуудал одоог хүртэл үүсгээгүй байна.

Шийдвэрлэсэн: Удирдлагад он удаан жил болсон барьцааны өглөгийг шийдвэрлэхталаар зөвлөмж хүргүүлэв.

4. Тайлант онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа 5,393.6 сая төгрөгөөр Эзний өмчийг нэмэгдүүлсэн, үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхдээ 3,542.0 сая төгрөгөөр эзний өмчийг хорогдуулсан бичилт хийсэн байна. Энэ нь УСНББОУС17, Сангийн Сайдын 2013 оны 269 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын өөрчлөлттэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгийг бүртгэхдээ СТОУС, УСНББОУС, бусад СС-ын баталсан холбогдох заавар, журмыг хэрэгжүүлж ажиллах, Санхүүгийн тайланг залруулав.

6. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнд дийлэнх буюу 70.2 хувийг эзлэж буй Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлаг, Нисэх хөдөлгөөний алба, Үйлдвэрлэлийн албадын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 12,960.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 10,348.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,604.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад арга хэмжээ авч ажиллах талаар асуудлын бүртгэлд тусгав.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдөр 2017 оны 3 дугаар сарын 03-ны 02/811 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн нь Төсвийн тухай хуульд заасан цаглабрын хугацааг 10 хоног хоцроосон. Мөн санхүүгийн нэгтгэсэн тайланг СС-ын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан журмын дагуу устгагдсан ажил гүйлгээг бусад баталгаажуулалтыг батлагдсан маягтын дагуу хавсралтаар ирүүлээгүй, тайлбар тодруулгыг бүрэн ирүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: ИНЕГ-ын санхүүгийн тайланд нэгтгэгддэг ААНБ-уудын санхүүгийн тайланг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан гаргах цаглабрт хугацаанд гаргуулж аудит хийлгэж байх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт орсон зүйлсийг тусгаагүй байна. Тухайлбал Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах тухай өөрчлөлт, Хүчингүй болсон элэгдэл тооцох журмыг мөрдлөгө болгох тухай дурьдсан байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, СТОУС, холбогдох СС-ын баталсан заавар, журмын дагуу өөрчлөлт оруулах зөвлөмж хүргүүлэв.

3. Ашиглагдаж буй нягтлан бодох бүртгэлийн програм нь мөнгөн гүйлгээний тайланг гаргадаггүй, санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргадаггүй гараар бэлтгэдэг учир дутагдалтай байна.

Шийдвэрлэсэн:Байгууллагаас програм шинэчлэгдэж байгаа тайлбар өгсөн тул дараагийн аудитаар шалгахар болов.

4. Тайлант онд Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа Газрын тусгай үйлчилгээний газрын эзэмшилд буй нийт 106.0 сая төгрөгийн 3 автомашиныг ЗТХЯ-ны зарим удирдах ажилтнуудын албан уналгад ашиглаж шатахуун, сэлбэг, жолоочийн зардал гаргадаг, мөн тус яамны 2 автомашины шатахуун, жолоочийг цалинжуулснаас тус газраас нийт 55.6 сая төгрөгийн урсгал зардал гарч, автомашины элэгдлийн зардал 55.7 сая төгрөг тооцогдсон байна. Мөн ЗТХЯ-ны ажилтнуудын гадаад томилолтод 38.9 сая төгрөгийг Үйлдвэрлэлийн албанаас гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:Удирдлагад тухайн шатны төсвөөс зөвхөн тухайн шатны төсвийг санхүүжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

11. Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан тайланд хийсэн аудитаар санхүүгийн тайлагнал, дансны бичилттэй холбоотой 324,638.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Тухайн шатны төсвөөс бусад төсвийн зардлыг санхүүжүүлж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байгаа нь анхаарал татахуйц чухал асуудал болж байна.

13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэлд ордог аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланг төсвийн шууд захирагчийн цаглабрт хугацаанд аудит хийлгэж, санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабрын хугацаанд ирүүлж аудит хийлгэх тал дээр анхаарах.

14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 326,866.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 324,638.7 сая төгрөгийн алдааг залруулж, 2,071.3 сая төгрөгийн зөрчил Энич аудит ХК-ийн тайланд албан шаардлагаар орсон тул 156.1сая төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлэв.

15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 5 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж байгаа талаар биелэлт гаргаж ирүүлсэн байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнд дийлэнх буюу 70.2 хувийг эзлэж буй Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлаг, Нисэх хөдөлгөөний алба, Үйлдвэрлэлийн албадын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 12,960.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 10,348.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2.604.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитын тайлан 6 хуудас, менежментийн захидалд 6 хуудас санхүүгийн бусад холбогдох материал хавсаргав.



**“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР”-ЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1:

Асуудал 1

Өр төлбөрийн талаар хуудас 3

Асуудал 2

Санхүүгийн тайлагналын талаар хуудас 4

Асуудал 3

НБББББ-ийн талаархуудас 5

Асуудал 4

Зардлын талаар хуудас 6

2017оны 3 сарын 25

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлэе.

Асуудал 1: Өр төлбөрийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Нийт 9,560.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлээс 5.9 сая төгрөгийн өрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь 2011 онд үүссэн "Идэр авиашн" ХХК-д өгөх навигацын барьцааны өглөг бөгөөд уг өглөгийг авах тухай асуудал одоог хүртэл үүсгээгүй байна.

ҮАГ-ынн зөвлөмж

Он удаан жил болсон барьцааны өглөгийг холбогдох арга хэмжээ авч, шийдвэрлэх

Эрсдэлүүд

Эзэн холбогдогч нь тодорхойгүй өр төлбөр байх

Үйлчлүүлэгч байгууллагын хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Асуудал 2: Санхүүгийн тайлагналын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдөр 2017 оны 3 дугаар сарын 03-ны 02/811 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн нь Төсвийн тухай хуульд заасан цаглабрын хугацааг 10 хоног хоцроосон. Мөн санхүүгийн нэгтгэсэн тайланг СС-ын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан журмын дагуу устгагдсан ажил гүйлгээг бусад баталгаажуулалтыг батлагдсан маягтын дагуу хавсралтаар ирүүлээгүй, тайлбар тодруулгыг бүрэн ирүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

ИНЕГ-ын санхүүгийн тайланд нэгтгэгддэг ААНБ-уудын санхүүгийн тайланг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан гаргах цаглабрт хугацаанд гаргуулж аудит хийлгэж байх

Эрсдэлүүд

Хууль, дүрэм, журам хэрэгжихгүй байх

Үйлчлүүлэгч байгууллагын хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Асуудал 3:НБББББ-ийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт орсон зүйлсийг тусгаагүй байна. Тухайлбал Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах тухай өөрчлөлт, Хүчингүй болсон элэгдэл тооцох журмыг мөрдлөгө болгох тухай дурьдсан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, СТОУС, холбогдох СС-ын баталсан заавар, журмын дагуу өөрчлөлт оруулах.

Эрсдэл:

НБББББ-т шинээр хэрэгжиж буй стандарт, журам, зааврын өөрчлөлтийг тусгаагүй байх.

Үйлчлүүлэгч байгууллагын хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа Газрын тусгай үйлчилгээний газрын эзэмшилд буй нийт 106.0 сая төгрөгийн 3 автомашиныг ЗТХЯ-ны зарим удирдах ажилтнуудын албан уналгад ашиглаж шатахуун, сэлбэг, жолоочийн зардал гаргадаг, мөн тус яамны 2 автомашины шатахуун, жолоочийг цалинжуулснаас тус газраас нийт 55.6 сая төгрөгийн урсгал зардал гарч, автомашины элэгдлийн зардал 55.7 сая төгрөг тооцогдсон байна. Мөн ЗТХЯ-ны ажилтнуудын гадаад томилолтод 38.9 сая төгрөгийг Үйлдвэрлэлийн албанаас гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл:

Бусад шатны төсвийг санхүүжүүлсэн байх

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг баримталж ажиллах

Үйлчлүүлэгч байгууллагын хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

СТ-1

/төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Залруулсан	Аудит хийгдсэн эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	23,642,589,949.35	44,795,664,219.41	-	44,795,664,219.41
Дансны авлага	35,945,375,537.63	38,316,294,766.94	-	38,316,294,766.94
Бусад авлага	15,935,163,834.27	5,629,915,374.05	74,345.45	5,629,989,719.50
Бараа материал	5,879,584,747.75	6,118,788,195.54	-	6,118,788,195.54
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,277,057,260.37	163,664,231.02	-	163,664,231.02
Бусад эргэлтийн хөрөнгө	8,961,938.66	5,547,500.00	-	5,547,500.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	82,688,733,268.03	95,029,874,286.96	74,345.45	95,029,948,632.41
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	181,961,502,845.57	184,906,392,888.28	-	184,906,392,888.28
Биет бус хөрөнгө	3,075,914,505.97	2,140,649,499.94	-	2,140,649,499.94
Хойшлогдсон татварын хөрөнгө	123,948,000.00	123,948,000.00	-	123,948,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	185,161,365,351.54	187,170,990,388.22	-	187,170,990,388.22
Нийт хөрөнгийн дүн	267,850,098,619.57	282,200,864,675.18	74,345.45	282,200,939,020.63
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
ӨР ТӨЛБӨР				
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР				
Дансны өглөг	753,071,345.36	1,343,849,221.65	-	1,343,849,221.65
Цалингийн өглөг	8,947,933.00	2,764,210.71	(751,265.36)	2,012,945.35
Татварын өр	239,684,008.78	3,067,641,455.32	1,144,697,591.92	4,212,339,047.24
НДШ - ийн өглөг	101,321,152.13	2,377,287.94	(247,102.71)	2,130,185.23
Урьдчилж орсон орлого	55,937,074.78	155,034,396.39	-	155,034,396.39
Бусад богино хугацаат өр төлбөр	2,906,896,144.70	2,596,514,833.48	74,945.45	2,596,589,778.93
Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,065,857,658.75	7,168,181,405.49	1,143,774,169.30	8,311,955,574.79
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			-	
Хойшлогдсон татварын өр	2,431,252,008.43	2,392,568,729.45	-	2,392,568,729.45
Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,431,252,008.43	2,392,568,729.45	-	2,392,568,729.45
Өр төлбөрийн нийт дүн	6,497,109,667.18	9,560,750,134.94	1,143,774,169.30	10,704,524,304.24
ЭЗДИЙН ӨМЧ				
Өмч			-	
-төрийн	225,569,216,113.02	227,420,879,156.08	(1,851,663,043.06)	225,569,216,113.02
Хуримтлагдсан ашиг	35,783,772,839.43	32,597,232,594.39	(0.01)	32,597,232,594.38
Тайлангийн үеийн ашиг		12,622,002,789.77	707,963,219.26	13,329,966,009.03
Эздийн өмчийн дүн	261,352,988,952.45	272,640,114,540.24	(1,143,699,823.81)	271,496,414,716.43
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	267,850,098,619.63	282,200,864,675.18	74,345.49	282,200,939,020.67

АУДИТ ХИЙГДСЭН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

СТ-2

/төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Залруулсан	Эцсийн үлдэгдэл
Төвлөрсөн төсвөөс хүлээн авсан орлого			3,063,212,095.10	3,063,212,095.10
Борлуулалтын орлого (цэвэр)	205,567,983,976.66	222,678,933,470.09	2,280,741,697.90	224,959,675,167.99
Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн	205,567,983,976.66	222,678,933,470.09	5,343,953,793.00	228,022,887,263.09
Борлуулалтын өртөг	84,269,762,867.18	81,227,329,686.25	(81,227,329,686.25)	
Нийт ашиг (алдагдал)	121,298,221,109.48	141,451,603,783.84	(141,451,603,783.84)	
Үндсэн үйл ажиллагааны зардал				
Цалин, хөлс болон ажиллагсадын тэтгэмж			44,876,400,064.39	44,876,400,064.39
Бараа үйлчилгээний зардал			144,962,174,423.53	144,962,174,423.53
Нийгмийн хамгааллын зардал			11,349,192,453.21	11,349,192,453.21
Элэгдэл хорогдлын зардал			15,918,388,044.68	15,918,388,044.68
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал			776,062,663.62	776,062,663.62
Хүүний орлого	807,285,630.89	625,606,394.82	(625,606,394.82)	
Бусад орлого	3,046,964,016.67	3,661,851,239.17	(3,661,851,239.17)	
Борлуулалт, маркетингийн зардал	-		-	
Ерөнхий ба удирдлагын зардал	104,741,102,726.83	125,306,693,878.07	(125,306,693,878.07)	
Санхүүгийн зардал	-		-	
Бусад зардал	13,365,055,483.28	11,349,192,453.20	(11,349,192,453.20)	
Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн				217,882,217,649.43
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	9,098,850,083.79	18,085,306,045.10	(18,085,306,045.10)	
Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал	4,875,349,564.04	12,622,002,789.77	(2,481,333,176.11)	10,140,669,613.66
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,052,528,214.64	8,995,230,958.54	-	8,995,230,958.54
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	9,322.22	6,900,000.00	3,478,490,749.94	3,485,390,749.94
Бусад			4,287,531,979.46	4,287,531,979.46
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг алдагдал				9,797,372,188.06
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,875,349,564.04	12,622,002,789.77	7,316,039,011.95	19,938,041,801.72
Орлогын татварын зардал	4,223,500,519.75	5,463,303,255.33	1,144,772,537.36	6,608,075,792.69
Татварын дараах цэвэр ашиг	4,875,349,564.04	12,622,002,789.77	707,963,219.26	13,329,966,009.03

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

СТ-3

/төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Залруулсан	Аудит хийсэн эцсийн үлдэгдэл
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	184,080,895,714.92	216,073,221,907.26	(27,856,344,886.85)	188,216,877,020.41
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		232,000.00	(232,000.00)	
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	45,516,543.00	269,058,638.29	(269,058,638.29)	
Буцаан авсан албан татвар		4,109,792.00	(4,109,792.00)	
Татаас, санхүүжилтийн орлого	17,495,738,941.65	23,521,849,439.98	(20,458,637,344.88)	3,063,212,095.10
Бусад мөнгөн орлого	265,513,336,870.40	312,911,100,466.27	(264,479,705,265.77)	48,431,395,200.50
Мөнгөн орлогын дүн	467,135,488,069.97	552,779,572,243.80	(313,068,087,927.79)	239,711,484,316.01
Цалин, хөлс, тэтгэмж			48,428,333,929.76	48,428,333,929.76
Бараа үйлчилгээний зардал			95,442,937.16	95,442,937.16
Нийгмийн хамгааллын зардал			4,007,061,100.00	4,007,061,100.00
Үйл ажиллагааны бусад зардал			152,026,597,495.21	152,026,597,495.21
Ажиллагчдад төлсөн	34,335,020,342.19	42,714,773,441.34	(42,714,773,441.34)	
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,028,608,345.33	9,631,086,467.77	(9,631,086,467.77)	
Бараа материал худалдан авахад төлсөн	2,854,091,224.93	3,039,456,015.70	(3,039,456,015.70)	
Ашиглалтын зардалд төлсөн	3,901,780,025.16	7,335,878,500.64	(7,335,878,500.64)	
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,536,068,712.54	3,548,235,057.46	(3,548,235,057.46)	
Хүүний төлбөрт төлсөн		-	-	
Татварын байгууллагад төлсөн	11,804,876,587.27	22,647,895,552.82	(22,647,895,552.82)	
Даатгалын төлбөрт төлсөн	1,288,042,034.23	162,354,560.68	(162,354,560.68)	
Бусад мөнгөн зарлага	392,410,650,261.63	428,545,843,793.51	(428,545,843,793.51)	
Мөнгөн зарлагын дүн	459,159,137,533.28	517,625,523,389.92	(313,068,087,927.79)	204,557,435,462.13
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,976,350,536.69	35,154,048,853.88	(0.00)	35,154,048,853.88
Мөнгөн орлогын дүн	799,142,989.00	625,606,394.82	(625,606,394.82)	
Хүлээн авсан хүүний орлого	799,142,989.00	625,606,394.82	-	625,606,394.82
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн-өөрийн хөрөнгө	10,816,690,256.89	8,450,535,452.50		8,450,535,452.50
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	122,218,333.08	1,361,030,665.14		1,361,030,665.14
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн-улсын төсвийн хөрөнгө хөрөнгө	1,175,256,574.06	4,815,014,861.00		4,815,014,861.00
Мөнгөн зарлагын дүн	12,114,165,164.03	14,626,580,978.64	-	14,626,580,978.64
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,315,022,175.03)	(14,000,974,583.82)	-	(14,000,974,583.82)
Мөнгөн зарлагын дүн	1,735,050,000.00	-	-	-
Төлсөн ногдол ашиг	1,735,050,000.00	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,735,050,000.00)	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	(5,073,721,638.34)	21,153,074,270.06	(0.00)	21,153,074,270.06
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	28,716,311,587.69	23,642,589,949.35	-	23,642,589,949.35
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	23,642,589,949.35	44,795,664,219.41	(0.00)	44,795,664,219.41

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

СТ-4

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Залруулсан	Аудит хийгдсэн эцсийн үлдэгдэл
2015 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	228,011,429,556.38	32,997,750,606.73	261,009,180,163.11	-	261,009,180,163.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-		39,726,164.90	39,726,164.90
Залруулсан үлдэгдэл	228,011,429,556.38	32,997,750,606.73	261,009,180,163.11	(39,726,164.90)	260,969,453,998.21
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		4,875,349,564.04	4,875,349,564.04	-	4,875,349,564.04
Бусад дэлгэрэнгүй орлого-өмнөх үе			-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	(2,442,213,443.36)	(2,089,327,331.34)	(4,531,540,774.70)	39,726,164.90	(4,491,814,609.80)
Зарласан ногдол ашиг		-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-	-	-	-
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	225,569,216,113.02	35,783,772,839.43	261,352,988,952.45	-	261,352,988,952.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-		(3,186,540,245.05)	(3,186,540,245.05)
Залруулсан үлдэгдэл	225,569,216,113.02	35,783,772,839.43	261,352,988,952.45	(3,186,540,245.05)	258,166,448,707.40
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		12,622,002,789.77	12,622,002,789.77	707,963,219.26	13,329,966,009.03
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	1,851,663,043.06	(3,186,540,245.04)	(1,334,877,201.98)	1,334,877,201.98	
Зарласан ногдол ашиг		-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-		-	
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	227,420,879,156.08	45,219,235,384.16	272,640,114,540.24	(1,143,699,823.81)	271,496,414,716.43